

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
даргын 2025 оны 06 сарын-ны өдрийнтоотын
хавсралт

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БАТЛАХ
ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН 2009 ОНЫ 143 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ /ХАГАС ЖИЛЭЭР/

2025.06.

Улиастай

№	Шалгуур үзүүлэлт	Гарах үр дүн	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал				
1	1.1.Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх: -Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; -Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм; -Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь; -Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт; -Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар. 1.2. Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга	Байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод болсон байна	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм; Төрийн үйлчилгээ, өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг байгууллагын цахим хуудсанд байршуулж тогтмол шинэчилж байна. Мөн www.shilen.gov.mn сайтад байршуулсан. Газрын харилцаатай холбоотой 45 гаруй нэр төрлийн үйлчилгээг 2021 оны 10 дугаар сарын 01-ээс цахим хэлбэрт бүрэн	100 100

	хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;		шилжүүлснээр иргэд газрын гэрээ гэрчилгээг өөрөө хэвлэн авах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд саналаа цахимаар өгөх, барьцааны гэрээ гэх мэт үйлчилгээг авахад Egazar.gov.mn цахим хуудсыг ашиглан ГХБХБГ-аар орох шаардлагагүй болсон. Цахимаар, гэрээсээ гар утаснаасаа санал өгөх, хэвлэн авах боломж бүрдсэн. Мөн киоск машинаас кадастрын зураг болон дээрх үйлчилгээг авч байна.	
	1.3. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;		Хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй чирэгдэлгүйгээр тогтмол өгч ажиллаж байна. Мөн байгууллагын цахим хуудсанд төлбөргүй болон төлбөртэй авах мэдээллийг байршуулан ажиллаж байна. Завхан аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар гэсэн цахим хуудас нээж ажиллуулж байна. Цахим хуудсанд иргэн, аж ахуйн нэгж байгууллага чөлөөтэй нэврэх боломжийг бүрдүүлсэн.	100
	1.4. Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;		Газар эзэмших, өмчлөх, барилга байгууламжийг улсын комисс хүлээн авах зэрэгт аймгийн засаг даргаар захирамж гаргуулахдаа аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээр тогтмол хянуулж дугаар авч ажилладаг. Мөн ГХБХБГ-ын даргын тушаал гаргуулахдаа Хууль эрх зүйн хэлтсээс заавар зөвлөмж авч ажилладаг. Дээрх тушаал шийдвэрийг газрын цахим хуудсанд байршуулсан.	100
	1.6. Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;		Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу санал хүсэлтийн хайрцаг ажиллуулж 7 хоног бүр иргэдийн санал хүсэлтийг хууль зүйн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна.	100
	1.7. Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх.		Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэж хариуг өгч ажиллаж байна. Тус газарт 2024 оны 11 сарын байдлаар 215 өргөдөл ирсэнээс 186 өргөдлийг шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. 29 өргөдөл шийдвэрлэгдхээр хяналтын шатанд хүлээгдэж байна.	100
Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал				
2	2.1. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх;	Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги,	Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль, хуулийг дагаж гарсан дүрэм журмын дагуу одоо ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, сул	100

		түүний хэрэгжилтийн явц, үр дүн нээлттэй, ил тод болсон байна	орон тоог ажиллаж байгаа албан хаагчдаас нөхөх бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журмыг gazar.gov.mn цахим хуудсандаа байршуулан ажиллаж байна.	
	2.2. Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх;		Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар gazar.gov.mn цахим хаягт байршуулан баяжилтыг тухай бүр хийж байна. Мөн www.shilen.gov.mn хаягт байршуулсан.	100
	2.3. Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх;		Сул орон тооны захиалгыг ГЗБГЗЗЕГ-т 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 105 албан бичгээр хүргүүлсэн. Сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас болон gazar.gov.mn хаягт байршсан.	
	2.4. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх.		Засгийн газрын 2023 оны 98 дугаар тогтоолоор баталсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж баталсан. Хөдөлмөрийн дотоод журмыг ГХБХБГ-ын даргын 2023 оны 03 сарын 10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчдын ажлыг үнэлж дүгнэх талаар заалт оруулж өгсөн.	
Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал				
3	3.1. Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх;	Байгууллагын төсөв боловсруулах, гүйцэтгэх, тайлагнах үйл явц нээлттэй, ил тод болсон байна	2023 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулан боловсруулж харъяа дээд байгууллага ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	
	3.2. Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх;		Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудас болон шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг байршуулан олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн.	

3.3. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх;		Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудас болон shilen.gov.mn сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг байршуулан олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн. Тус газрын харъяа байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн онлайн программын шинэчлэлтийг 2024 оны 3-р улирлаас эхлэн нэвтрүүлж батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэж, санхүүгийн хяналтыг сайжруулж хугацаат мэдээ, тайланг хянан баталгаажуулж холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.	
3.4. Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;		2023 оны жилийн эцсийн байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар 1283878 /нэг сая хоёр зуун наян гурван мянга найман зуун далан найм/ төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг 2024 оны 06 сарын 05-ны өдөр барагдуулсан.	
3.5. Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх;		Тухайн жилийн батлагдсан төсөвт ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт ороогүй. Тус газар нь 2024 онд 46 орон тоотой, 1862237.8 мянган төгрөгийн төсөвтэй ажилласан. Үүнээс: • Цалин хөлс, нэмэгдэл урамшилд 890250.8 мянган төгрөг • Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 113298.0 мянган төгрөг • Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14918.1 мянган төгрөг • Хангамж бараа материалын зардал 11044.6 мянган төгрөг • Норматив зардал 66.6 мянган төгрөг • Урсгал засварын зардал 31450.4 мянган төгрөг • Дотоод албан томилолт 4493.6 мянган төгрөг • Бусдаар гүйцэтгэлүүлэх ажил үйлчилгээний зардал 52.0 мянган төгрөг • Бараа үйлчилгээний бусад зардал 53729.9 мянган төгрөг	

			Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал 118119.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан ба үндсэн үйл ажиллагааны орлогоос 60568.1 мянган төгрөгийн орлого орж үйл ажиллагаандаа зарцуулсан байна.	
	3.6. Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх;		Газрын тухай хууль Барилгын тухай хуулиудад заасан байгууллагын үйл ажиллагаатай холбоотой төлбөр хураамжийг үйлчлүүлэгчээс авч орлогын төлөвлөгөөний дагуу ГЗБГЗЗЕГ-т төвлөрүүлж байна.	
	3.7. Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх.		Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамжийг тухайн дансанд тушаалгаж тооцоо нийлж хэвшсэн. Төлбөрийн даалгавар үүсгэсэнээр иргэн аж ахуйн нэгж байгууллага Egazar.gov.mn сайт болон утасны апплейкшнээс газрын төлбөрөө төлөх боломж бүрдсэн.	
			Монгол улсын засгийн газрын 2024 оны 10 сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэх: С.Мягмарсүрэн

Холбоо барих утас: 99773365

Цахим шуудан: myagmarsuren9933@gmail.com

